

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020 оны 05 дугаар сарын 14

1. Төрийн Худалдан авах ажиллагааны газар нь **Ховд голоос 5000га газар услах услалтын системийн толгойн барилга, суваг, хоолойн зураг төсөв-ыг** хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй эрх бүхий хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээний захиалагч нь Ховд аймгийн орон нутгийн өмчийн газар бөгөөд иж бүрдэл нь: Ажлын даалгавар.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14–16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах материалыг баталгаажуулж ирүүлнэ.
 - Байгууллагын ерөнхий танилцуулга, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, Байгаль орчин аялал жуулчлалын яамны Усны мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хуулбар.
 - Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл
 - Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хүчний чадавхын талаарх мэдээлэл /голлох инженер техникийн ажилчдын ур чадварын мэдээлэл, туршлага, мэргэжлийн дипломын хуулбар/
- Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхын мэдээлэл **2018, 2019** онуудын санхүүгийн тайлан, аудитын дгнэлийн хамт ирүүлэх, татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй tender.gov.mn цахим хаягаар татаж харах тул
- Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийг** хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн орон нутгийн цагаар 10:00 цагаас өмнө** ирүүлнэ үү. Мэдүүлгийг монгол хэл дээр ирүүлнэ.

**Ховд аймаг, Жаргалант сум,
Цамбагарав баг Ард Аюушын талбай
Аймгийн ЗДТГ-ын байр 4 давхар 407 тоот
Утас: 70434401 вэб: www.tender.gov.mn**